

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	2
ОРШИЛ.....	3
ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС.....	4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2020 оны 7 дугаар сард.....	5
Хүснэгт 2. Инфляцад бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 7 дугаар сард	5
Хүснэгт 3 Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 7 дугаар сард.....	5
Хүснэгт 4. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 7 дугаар сард.....	7
Хүснэгт 5. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 7 дугаар сард.....	7

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар.....	4
Зураг 2. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар.....	6
Зураг 3. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар.....	6
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар.....	8
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019, 2020 оны 7 дугаар сард.....	8
Зураг 6. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар.....	9
Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул, 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	10
Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	10
Зураг 9. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	11
Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж буй нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	11
Зураг 11. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 6 дугаар сард сард (өмнөх оны мөн үеэс).....	12
Зураг 12. Аймгуудад зарагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12

ОРШИЛ

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн хэрэглээний үнийн индексийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан хэрэглээний үнийн улсын индексийн тооцоонд аймгийн хэрэглээний үнийн индексийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.


2017 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх сараас 0.5 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны эцсээс 3.3 хувь, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6.8 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 3.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 1.5 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.3 хувиар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.0 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 27.7 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.4 хувиар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0.1 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2020 оны 7 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020 VII	2020 VII	2020 VII
		2019 VII	2019 XII	2020 VI
Ерөнхий индекс	100.0	103.4	103.3	100.5
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	107.5	113.0	101.3
Согтууруулах ундаа, тамхи	4.4	104.6	103.6	100.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	104.3	101.3	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	102.5	100.8	100.2
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	103.5	101.6	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	102.8	102.0	100.2
Тээвэр	14.4	93.7	93.6	100.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.1	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	98.9	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	4.8	109.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	106.4	103.8	100.2
Бусад бараа, үйлчилгээ	5.4	104.3	102.0	100.3

Инфляцын түвшин 2017 оны 7 дугаар сард 3.4 хувь, 2018 оны 7 дугаар сард 7.7 хувь, 2019 оны 7 дугаар сард 7.7 хувь гарч байсан бол 2020 оны 7 дугаар сард 3.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.3 пунктээр бүүрсан байна.

Хүснэгт 2. Инфляцад бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 7 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII
Ерөнхий индекс	3.4	7.7	7.7	3.4
Хүнсний бараа, ундаа, ус	0.4	2.9	2.5	2.0
Согтууруулах ундаа, тамхи	0.1	0.4	0.1	0.2
Хувцас, бөс бараа, гутал	0.3	0.5	1.5	0.7
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.2	1.3	1.2	0.2
Гэр ахуйн тавилга, бараа	0.1	0.3	0.2	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.2	0.4	0.3	0.1
Тээвэр	1.4	0.9	0.4	-0.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.0	0.3	0.5	0.0
Боловсролын үйлчилгээ	0.2	0.3	0.3	0.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.0	0.2	0.3	0.2
Бусад бараа, үйлчилгээ	0.4	0.3	0.3	0.2

Инфляцын түвшин 2020 оны 7 дугаар сард улсын хэмжээнд 3.4 хувь гарсны 2.0 нэгж буюу 59.0 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 0.7 нэгж буюу 20.3 хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 0.5 нэгж буюу 14.3 хувь нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


Хүснэгт 3. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 7 дугаар сард

Үзүүлэлт	2018 VII		2019 VII		2020 VII	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	7.7	100.0	7.7	100.0	3.4	100.0
Импортын барааны нөлөө	2.8	36.4	2.5	32.5	0.7	20.0

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.


Инфляц 2020 оны 7 дугаар сард 3.4 хувь гарсны 19.3 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 12.5 пунктээр буурсан байна.

Зураг 2. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2019 оны 7 дугаар сард 8.6 хувиар, 2020 оны 7 дугаар сард 7.1 хувиар өсөж, өсөлтийн хурдац 1.5 пунктээр, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2019 оны 7 дугаар сард 7.3 хувиар, 2020 оны 7 дугаар сард 1.8 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.5 пунктээр тус тус буурчээ.

Зураг 3. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2019 оны 7 дугаар сард 7.6 хувиар, 2020 оны 7 дугаар сард 3.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.2 пунктээр, үйлчилгээний бүлгийн үнэ 2019 оны 7 дугаар сард 7.2 хувиар, 2020 оны 7 дугаар сард 3.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.8 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 4. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 7 дугаар сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	107.4	108.8	105.3	106.4	104.7	107.9
2019 VII	Бараа	107.6	109.1	104.8	106.9	105.2	108.9
	Үйлчилгээ	106.7	108.0	107.3	104.6	103.0	104.1
	Ерөнхий индекс	103.4	103.2	103.0	103.6	103.9	104.7
2020 VII	Бараа	103.4	103.3	102.2	103.7	103.9	104.4
	Үйлчилгээ	103.4	102.9	105.7	103.2	103.6	106.3


Хэрэглээний үнийн индексийг бараа, үйлчилгээний бүлгээр авч үзэхэд барааны бүлгийн үнэ 2020 оны 7 дугаар сард Зүүн бүсэд 4.4 хувиар өссөн нь хамгийн их, үйлчилгээний бүлгийн үнэ Зүүн бүсэд 6.3 хувиар өссөн нь хамгийн их өсөлт байлаа.

Хүснэгт 5. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 7 дугаар сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	107.4	108.8	105.3	106.4	104.7	107.9
2019 VII	Хүнс	108.6	109.1	106.6	108.0	106.7	113.0
	Хүнсний бус	106.9	108.6	104.9	105.9	103.9	105.9
	Ерөнхий индекс	103.4	103.2	103.0	103.6	103.9	104.7
2020 VII	Хүнс	107.1	106.7	104.6	108.5	108.9	106.9
	Хүнсний бус	101.8	101.5	102.4	101.7	101.7	103.8


Хэрэглээний үнийн индексийг хүнс, хүнсний бус бүлгээр авч үзэхэд хүнсний бүлгийн үнэ 2020 оны 7 дугаар сард Төвийн бүсэд хотод 8.9 хувиар өссөн нь хамгийн их, хүнсний бус бүлгийн үнэ Зүүн бүсэд 3.8 хувиар өссөн нь хамгийн их өсөлт байв.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 6.2 хувь, хонины ястай махны үнэ 6.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019, 2020 оны 7 дугаар сард



Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 3.8 хувь, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 3.9 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 7.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.4 хувиар буурсан байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны эцсээс 3.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 14.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.2 хувиар буурсан байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 22.1 хувь буюу 76 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 5.8 хувь буюу 20 бараа, үйлчилгээний үнэ буурч, 72.1 хувь буюу 248 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 42 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 6. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард 15 077 төгрөгийн үнэтэй байгаа нь 2017 оны 7 дугаар сараас 65.5 хувь, 2018 оны 7 дугаар сараас 39.4 хувь, 2019 оны 7 дугаар сараас 3.3 хувиар өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард 12 758 төгрөгийн үнэтэй байгаа нь 2017 оны 7 дугаар сараас 62.8 хувь, 2018 оны 7 дугаар сараас 40.5 хувь, 2019 оны 7 дугаар сараас 3.9 хувиар өссөн байна.

Зураг 9. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалж буй хонины ястай махны 1 кг дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард 10 648 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2017 оны 7 дугаар сараас 60.4 хувь, 2018 оны 7 дугаар сараас 41.4 хувь, 2019 оны 7 дугаар сараас 6.0 хувиар тус бүр өссөн байна.

Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж буй нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард 1 396 байгаа нь 2017 оны 7 дугаар сараас 14.4 хувь, 2018 оны 7 дугаар сараас 22.5 хувь, 2019 оны 7 дугаар сараас 24.0 хувиар буурсан байна.


Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 1.3-7.1 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард Ховд аймагт 1.3 хувиар өссөн нь хамгийн бага, Дундговь, Дорнод аймагт 7.1 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 11. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 7 дугаар сард (өмнөх оны мөн үеэс)



Зураг 12. Аймгуудад зарагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр



Аймгуудад 2020 оны 7 дугаар сард зарагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 2019 оны 7 дугаар сараас дунджаар 712 төгрөгөөр их байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард Баян-Өлгий аймагт 7774 төгрөг байгаа нь хамгийн доод үнэ бол Төв аймагт 10277 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.